

Аймгийн Засаг даргын орлогчийн  
2026 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн  
02/209 дүгээр албан бичгийн нэгдүгээр хавсралт

СҮХБААТАР АЙМГИЙН СЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ИД ТОД БАЙДЛЫН  
САНААЧИЛГЫН ДЭД ЗӨВЛӨЛИЙН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Үйл ажиллагааны чиглэл	Хэрэгжүүлэх хугацаа	Хариуцах эзэн	Хамтрах талууд	Биелэлт
<b>1. Судалгаа, мэдээ тайлан гаргах ажлын хүрээнд</b>					
1	Аймгийн дэд зөвлөлийн бүрэлдэхүүнийг зөвлөмж чиглэл өгөх, санал солилцох, төлөвлөгөөний хэрэгжилт хүлээн авах	V сард	Хөгжлийн бодлогыг төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс	"Их бага баян шарга сан" ТББ	Аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ-ийн дарга, холбогдох мэргэжилтэн, дэд зөвлөлийн гишүүдийн төлөөлөл нар "Их бага баян шарга" ТББ-ийн тэргүүнтэй хамтран 2025 оны 05-р сард ОУИТБС-ын дэд зөвлөлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг эрчимжүүлэх уулзалтыг зохион байгуулж ажилласан. Холбогдох мэдээллийг солилцон ажилласан. Биелэлт-90%
2	Орон нутагт хүлээн авсан татвар, төлбөр, хандив, дэмжлэгийн мэдээ тайланг ОУИТБС-ын сүлжээгээр гаргах, аймгийн цахим хуудас дээр байршуулах	4/15-ны дотэр	Санхүү, төрийн сангийн хэлтэс,	Татварын хэлтэс, сумдын ЗДТГ, бусад байгууллага	ОУИТБС-ын дэд зөвлөлийн 2024 онд хэрэгжүүлсэн арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт, 2025 онд хэрэгжүүлэх ажил, арга хэмжээний төлөвлөгөөг аймгийн Засаг даргын орлогчоор 2025 оны 03 дугаар сарын 26-ны өдөр батлуулан ОУИТБС-ын засаглалыг сайжруулах ажлын албанд хүргүүлсэн. 2024 оны аймгийн цахим тайланг ОУИТБС-ын ажлын албанаас өгсөн чиглэл, зааварчилгааны дагуу түүврээр сонгогдсон аж ахуйн мэдээллийг аймгийн Татварын газраар гаргуулан хугацаанд нь хүргүүлсэн.

					Биелэлт-100%
3	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, тэдгээрт оруулсан өөрчлөлт, байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан гаргах	XII сард	Байгаль орчны газар	Сумдын ЗДТГ	2025 онд аймгийн хэмжээнд ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулсан 16 аж ахуй нэгж Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлуулсан. Аймгийн Байгаль орчны газарт төлөвлөгөөний биелэлтээ дүгнүүлэх хүсэлтээ ирүүлсэн аж ахуй нэгжүүдэд ажлын хэсэг ажиллан төлөвлөгөөний хэрэгжилтийг дүгнэн ажиллаж байна. Биелэлт -85%
4	Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, өөрчлөлт, тайлан, зардлын 50%-ийг тусгай дансанд төвлөрүүлсэн байдал, түүний зарцуулалт, буцаан төлөлтийн мэдээ, тайланг компани тус бүрээр гаргаж, дэд зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх	IV улиралд	БОНХОБТ, Байгаль орчны газар	Дэд зөвлөл, Сумдын Засаг дарга	Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуй нэгжүүдийн байгаль орчныг хамгаалах зардлын 50 хувийг төрийн захиргааны төв байгууллага, хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн байгаль орчныг хамгаалах зардлын 50 хувийг тухайн сум, дүүргийн Тамгын газрын дансанд төвлөрүүлдэг. Орон нутгаас гарах тайланг хугацаанд холбогдох газруудад хүргүүлэн ажилласан. Тус заалтын хэрэгжилтийг иргэдэд нээлттэй мэдээлэх талаар холбогдох сумд, БОГ-т чиглэл өгч ажилласан. 2026 оны 03 дугаар сард хүргэхээр бэлтгэл ханган ажиллаж байна. Биелэлт-70%
5	АМТ-ын тухай хуулийн 42 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 179 дүгээр тогтоолын хэрэгжилтийг ханган <a href="http://www.iitodgegee.mn">www.iitodgegee.mn</a> сайтад шинээр байгуулсан гэрээг байршуулах	Жилдээ	БОНХОБТХ	БОГ, Сумдын Засаг дарга	2025 онд аймгийн Засаг дарга, холбогдох сумын Засаг дарга ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нартай "Орон нутгийн хамтын ажиллагааны гурвалсан гэрээ" байгуулах уулзалт, хэлцлийг аймаг, сумдын удирдлага, ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нарыг оролцуулан 2025 оны 04 дүгээр сарын 28, 29-ний өдрүүдээс эхлэн

					<p>зохион байгуулж ажилласан. 2025 онд 19 аж ахуй нэгжтэй аймаг, сум, компани гурвалсан гэрээ байгуулж баталгаажуулсан, <a href="http://www.iltodgeree.mn">www.iltodgeree.mn</a> эрдэс баялгийн гэрээний мэдээллийн санд 2025 онд байгуулсан хамтын ажиллагааны 18 аж ахуй нэгжийн гэрээг байршуулсан.</p> <p>Биелэлт 90%</p>
<b>2. Иргэдэд нээлттэй ил тод мэдээлэх, олон талын оролцоотой хэлэлцүүлэг зохион байгуулах ажлын хүрээнд</b>					
1	<p>ОУИТБС-ын цахим тайлангийн систем шинэчлэгдэж байгаатай холбогдуулан аймгийн уул уурхайн тусгай зөвшөөрөл, гэрээний мэдээллийг сумд, иргэдэд ойлгомжтой, хүртээмжтэй хэлбэрээр аймгийн цахим сайтад байршуулах</p>	<p>II, IV улиралд</p>	<p>БОНХОБТХ, СТСХ, БОГ</p>	<p>Дэд зөвлөл</p>	<p>2025 оны 04 дүгээр сарын 28, 29-ний өдрүүдэд сум, орон нутгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг дарга, иргэдэд уул уурхайн салбарын үйл ажиллагаа мэдээллийг хүргэх, танилцуулах ажлыг “Хариуцлагатай уул уурхай, орон нутгийн хамтын ажиллагаа 2025” жилийн уулзалт, арга хэмжээгээр Нутгийн захиргааны байгууллага, мэргэжлийн байгууллагуудаас илтгэл мэдээлэл өгч ажиллаж, хэлцэл зохион байгуулж ажилласан.</p> <p>Аймгийн цахим сайтуудаар мэдээллийг тухай бүр хүргэн ажиллаж байна.</p> <p>Биелэлт-80%</p>
2	<p>ОУИТБС-ын дэд зөвлөлийн гишүүдийг чадавхжуулах, мэдлэг олгох сургалтад хамруулах</p>	<p>II, IV улиралд</p>	<p>БОНХОБТХ</p>	<p>Хамтын ажиллагааны хороо</p>	<p>Энэ онд аймгийн цахим тайланг гаргах талаар ОУИТБС-ын ажлын албанаас өгсөн чиглэл, зааварчилгаа, сургалтад аймгийн ЗДТГ-ын БОНХОБТХ, СТСХ-ийн мэргэжилтнүүдийг оролцуулсан мөн ажлын албанаас зохион байгуулсан мэдээлэл солилцох цахим уулзалтад аймгийн дэд зөвлөлийн төлөөлүүд саналаа илэрхийлж</p>

					<p>оролцсон.</p> <p>Мөн 2025 оны 10 дугаар сарын 15-ны өдөр ОУИТБС-ын ажлын албанаас ил тод сайтад гэрээг оруулах талаарх цахим сургалтад оролцож, тулгамдаж байгаа асуудалд санал солилцон мэдээлэл авч ажилласан.</p> <p>Биелэлт-90%</p>
<b>3. Хамтын ажиллагаа, түшлэлийг хөгжүүлэх, чадавх бэхжүүлэх ажлын хүрээнд</b>					
1	<p>Төр, компани, иргэний нийгмийн харилцан ойлголцол, хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор сумдын Дэд зөвлөлийг чадавхжуулах, үйл ажиллагааг эрчимжүүлэх талаар зөвлөмж чиглэл өгч, сумдын төлөөллийг холбогдох сургалт, хэлэлцүүлэгт хамруулах /Сүхбаатар, Асгат, Эрдэнэцагаан, Түвшинширээ, Уулбаян, Мөнххаан, Түмэнцогт сумд/</p>	Жилдээ	ОУИТБС-ын ажлын алба, Аймгийн ЗДТГ	Дэд зөвлөл	<p>Аймгийн ЗДТГ-аас 2025 оны 02, 04-р сард зохион байгуулсан агентлаг, сумдын удирдах ажилчдын зөвлөгөөн семинар болон Уул уурхайн салбарын жилийн уулзалт, хэлэлцүүлгийн арга хэмжээний үеэр уул уурхайн ашиглалт, тээвэрлэлтийн үйл ажиллагаа явагдаж байгаа 7 сумдын удирдлага, албан хаагч нарт сумын дэд зөвлөлийн үйл ажиллагааг дэмжих, эрчимжүүлэх талаар зөвлөмж чиглэлийг аймгийн Засаг даргын орлогч, Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга нар өгч ажилласан.</p> <p>2025 оны 10 дугаар сарын 09, 10-ны өдрүүдэд Хэнтий аймагт зохион байгуулагдсан уул уурхайн бүсийн зөвлөгөөнд Аймгийн Засаг даргын орлогчоор ахлуулсан төлөөлөл оролцсон.</p> <p>Тус зөвлөгөөнд Эрдэнэцагаан, Сүхбаатар сумдын Засаг дарга нарыг мөн оролцуулсан.</p> <p>Биелэлт-90%</p>
2	<p>ОУИТБС-ын 5 зорилтыг хэрэгжүүлэх, сумдын дэд зөвлөлийг чадавхжуулах сургалт зохион байгуулах</p>	II, III улиралд	"Их бага баян шарга сан" ТББ	Дэд зөвлөл	<p>2025 оны 09, 10 дугаар саруудад Нэгдсэн үндэсний байгууллага, азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжиж байгаа Интегра төсөл, Эрдэнэцагаан, Түмэнцогт сумын ЗДТГ хамтран сум тус бүртээ зохион</p>

					<p>байгуулсан Байгаль орчин, уул уурхайн салбарын тулгамдсан асуудал сэдэвт уулзалт хэлэлцүүлэгт дэд зөвлөлийн нарийн бичгийн дарга, аймгийн Байгаль орчны газрын дарга нарыг паналистаар оролцуулж орон нутгийн бодлого, салбарын мэдээллийг иргэдэд танилцуулан ажилласан.</p> <p>Биелэлт-70%</p>
--	--	--	--	--	---

**СҮХБААТАР АЙМГИЙН ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН САНААЧИЛГЫН ДЭД ЗӨВЛӨЛ**

ТАЙЛАНГ НЭГТГЭСЭН:  
 АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН БҮС, ОРОН НУТГИЙН  
 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН  
 АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

ХЯНАСАН:  
 АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ,  
 ОУИТБС-ЫН ДЭД ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

М. ГЭРЭЛТ-ОД



Б. БАТБААТАР